

**ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧДАД ЗОРИУЛСАН
МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС**

**2019 КОРОНАВИРУСЫН ЦАР ТАХЛААС (КОВИД-19)
СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИНЫГ
18 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫХАНД
2019 КОРОНАВИРУСЫН ЦАР ТАХЛААС (КОВИД-19) СЭРГИЙЛЭХ
ЗОРИЛГООР ЖАНССЕН КОВИД-19 ВАКЦИН**

Жанссен КОВИД-19 вакциныг 18 ба түүнээс дээш насны, ХЭЧХГ-аас эрх олгосон эсвэл зөвшөөрөгдсөн бусад КОВИД-19 вакцин хүртээмжгүй эсвэл эмнэлзүйн хувьд тохиромжгүй хүмүүс, мөн Жанссен КОВИД-19 вакцин хийлгэхгүй бол КОВИД-19 вакцинд хамрагдах боломжгүй 18 ба түүнээс дээш насны хүмүүс хийлгэх боломжтой. Жанссен КОВИД-19 вакцин нь үхэлд хүргэж болзошгүй тромбоцитийн (таны биеийн цус алдалтыг зогсооход тусалдаг цусны эсүүд) хэмжээ доод түвшинд хүрэх байдал үүсгэж болзошгүй.

Одоогоор КОВИД-19 цар тахал үүсээд байгаа тул танд SARS-CoV-2 вирусаар дамжин халдварладаг Коронавирус 2019 (КОВИД-19) өвчнөөс урьдчилан сэргийлэх Жанссен КОВИД-19 вакциныг санал болгож байна.

Энэхүү Мэдээллийн Хуудас нь танд Жанссен КОВИД-19 вакцины давуу тал, эрсдэлүүдийн талаар ойлгоход туслах мэдээлэл агуулдаг.

Жанссен КОВИД-19 вакцин таныг КОВИД-19-ийн халдвар авахаас сэргийлнэ.

Жанссен КОВИД-19 вакцины тухай мэдээллийг энэхүү Мэдээллийн Хуудаснаас уншина уу. Хэрэв танд асууж лавлах зүйл байвал вакцин нийлүүлэгчтэй холбоо барина уу.

Жанссен КОВИД-19 вакциныг 18 ба түүнээс дээш насны, ХЭЧХГ-аас эрх олгосон эсвэл зөвшөөрөгдсөн бусад КОВИД-19 вакцин хүртээмжгүй эсвэл эмнэлзүйн хувьд тохиромжгүй хүмүүс, мөн Жанссен КОВИД-19 вакцин хийлгэхгүй бол КОВИД-19 вакцин хийлгэх боломжгүй 18 ба түүнээс дээш насны хүмүүс хийлгэх боломжтой:

- Нэг тун анхан шатны вакцинжуулалт.
- Жанссен КОВИД-19 вакцин хийлгэж анхан шатны вакцинжуулалтад хамрагдсаны дараа хийх нэг нэмэлт тун.
- Эрх бүхий эсвэл зөвшөөрөгдсөн КОВИД-19 вакцин хийлгэж анхан шатны вакцинжуулалтад хамрагдсаны дараа хийх нэг нэмэлт тун.

Жанссен КОВИД-19 вакцин нь хүн бүрийг хамгаалж чадахгүй байж магадгүй.

Энэхүү Мэдээллийн Хуудас цаашид шинэчлэгдэнэ. Хамгийн сүүлийн Мэдээллийн Хуудсыг www.janssencovid19vaccine.com вебсайтаас үзнэ үү.

ЭНЭХҮҮ ВАКЦИНЫГ ХИЙЛГЭХИЙН ӨМНӨ ТА ЮУ МЭДЭХ

ХЭРЭГТЭЙ ВЭ, КОВИД-19 ГЭЖ ЮУ ВЭ?

КОВИД-19 өвчин нь SARS-CoV-2 хэмээх коронавирусаас үүсдэг. Энэ төрлийн коронавирус урьд өмнө гарч байгаагүй. Та вирус тээж буй хүнтэй харьцсанаар КОВИД-19-ийн халдвар авч болзошгүй. Энэ бол ихэвчлэн бусад эрхтэнд нөлөөлж болзошгүй амьсгалын замын өвчин юм. КОВИД-19-ийн халдвар авсан хүмүүст хөнгөн хэлбэрээс эхлээд хүнд хэлбэрийн өвчний олон төрлийн шинж тэмдэг илэрсэн гэж бүртгэгдсэн. Вирусын халдвар авснаас хойш 2-14 хоногийн дараа шинж тэмдэг илэрч болно. Нийтлэг шинж тэмдгүүд: халуурах, бие арзайх, амьсгалахад хүндрэлтэй болох, ханиалгах, ядрах, булчин ба биеийн өвдөх, толгой өвдөх, үнэртэх болон амтлах чадвараа алдах, хоолой хөндүүрлэх, хамар битүүрэх, нус гоожих, дотор муухайрах, бөөлжих, гүйлгэх.

ЖАНССЕН КОВИД-19 ВАКЦИН ГЭЖ ЮУ ВЭ?

Жанссен КОВИД-19 вакцин нь КОВИД-19-ийн халдвараас сэргийлэх боломжтой батлагдаагүй вакцин юм.

ЯХЗ-ийн дагуу ХЭЧХГ 18 ба түүнээс дээш насны, ХЭЧХГ-аас эрх олгосон эсвэл зөвшөөрөгдсөн бусад КОВИД-19 вакцин хүртээмжгүй эсвэл эмнэлзүйн хувьд тохиромжгүй хүмүүс, мөн Жанссен КОВИД-19 вакцин хийлгэхгүй бол КОВИД-19 вакцинд хамрагдах боломжгүй 18 ба түүнээс дээш насны хүмүүст Жанссен КОВИД-19 вакциныг яаралтай хэрэглэхийг зөвшөөрсөн.

ЯХЗ талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд Мэдээллийн Хуудасны төгсгөлд буй “Яаралтай хэрэглэх зөвшөөрөл (ЯХЗ) гэж юу вэ?” гэсэн хэсгийг үзнэ үү.

ТА ЖАНССЕН КОВИД-19 ВАКЦИНЫГ ХИЙЛГЭХЭЭС ӨМНӨ ВАКЦИН НИЙЛҮҮЛЭГЧДЭЭ ЮУГ МЭДЭЭЛЭХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

Вакцин нийлүүлэгчдээ дараах зүйлсийг оролцуулан эрүүл мэндийнхээ байдлын талаар мэдэгдэнэ үү:

- ямар нэгэн харшилтай,
- халуурч байгаа,
- цус алдалтын эмгэгтэй эсвэл цус шингэлэгч эм хэрэглэдэг,
- тромбоцитийн (таны биеийн цус алдалтыг зогсооход тусалдаг цусны эсүүд) доод хэмжээнд хүрч,
- дархлаа суларсан эсвэл таны дархлааны тогтолцоог өөрчлөх эм хэрэглэдэг,
- жирэмсэн эсвэл жирэмслэх төлөвлөгөөтэй,
- хөхүүл,

- өөр ямар нэгэн КОВИД-19-ийн вакцин тариулсан,
- тарилгаас шалтгаалан ухаан алдаж байсан.

ХЭН ЖАНССЕН КОВИД-19 ВАКЦИНЫГ ХИЙЛГЭХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

ХЭЧХГ 18 ба түүнээс дээш насны, ХЭЧХГ-аас эрх олгосон эсвэл зөвшөөрөгдсөн бусад КОВИД-19 вакцин хүртээмжгүй эсвэл эмнэлзүйн хувьд тохиромжгүй хүмүүс, мөн Жанссен КОВИД-19 вакцин хийлгэхгүй бол КОВИД-19 вакцинд хамрагдах боломжгүй 18 ба түүнээс дээш насны хүмүүст Жанссен КОВИД-19 вакциныг яаралтай хэрэглэхийг зөвшөөрсөн.

ХЭН ЖАНССЕН КОВИД-19 ВАКЦИНЫГ ХИЙЛГЭЖ БОЛОХГҮЙ ВЭ?

Та дараах тохиолдолд Жанссен КОВИД-19 вакциныг хийлгэж болохгүй:

- вакцины анхны тунгийн дараа маш хүчтэй харшлын урвал үзүүлсэн.
- энэ вакцины аль нэг найрлага хүчтэй харшлын урвал үзүүлсэн.
- Жанссен КОВИД-19 вакцин эсвэл Астразенека КОВИД-19 вакцины (АНУ-д эрх олгоогүй буюу зөвшөөрөгдөөгүй) дараа тромбоцитийн (таны биеийн цус алдалтыг зогсооход тусалдаг цусны эсүүд) доод хэмжээнд хүрч, цусны бүлэгнэл үүссэн.

ЖАНССЕН КОВИД-19 ВАКЦИН ЯМАР НАЙРЛАГАТАЙ ВЭ?

Жанссен КОВИД-19 вакцин доорх найрлагатай: SARS-CoV-2 баяжуулалтын уураг, нимбэгийн хүчил моногидрат, тринатрийн цитрат дигидрат, этанол, 2-гидроксипропил-β-циклодекстрин (HBCD), полисорбат-80, натрийн хлоридыг илэрхийлдэг репликаци-чадамжгүй аденовирусийн 26 төрөл.

ЖАНССЕН КОВИД-19 ВАКЦИНЫГ ЯАЖ ХЭРЭГЛЭХ ВЭ?

Жанссен КОВИД-19 вакциныг булчинд тарилга хэлбэрээр хийнэ.

Анхан шатны вакцинжуулалт

Жанссен КОВИД-19 вакциныг **нэг тунгаар** хийдэг.

Нэмэлт тун

- Жанссен КОВИД-19 вакцины эхний тунг хийлгэснээс хойш хамгийн багадаа хоёр сарын дараа КОВИД-19 вакцины нэг нэмэлт тун хийх боломжтой.
- Жанссен КОВИД-19 вакцины нэг нэмэлт тунг өөр эрх бүхий буюу зөвшөөрөгдсөн КОВИД-19 вакцины анхан шатны вакцинжуулалтад хамрагдсаны дараа хийж болно. Нэмэлт тун хийлгэх хугацааны талаар эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчээсээ асууна уу.

ЖАНССЕН КОВИД-19 ВАКЦИНЫГ ӨМНӨ НЬ ХЭРЭГЛЭЖ БАЙСАН УУ?

Жанссен КОВИД-19 вакцин нь батлагдаагүй вакцин юм. Клиник тандалтаар 18 ба түүнээс дээш насны 61,000 гаруй хүн Жанссен КОВИД-19 вакцинд хамрагдсан байна. 2021 оны 2-р сарын 27-ноос хойш хэдэн сая хүн ЯХЗ-ийн дагуу вакцинд хамрагдсан.

ЖАНССЕН КОВИД-19 ВАКЦИНЫ АШИГ ТУС ЮУ ВЭ?

Жанссен КОВИД-19 вакцин нь КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлдэг болохыг тогтоосон. Одоогийн байдлаар КОВИД-19-өөс хамгаалах чадварын үргэлжлэх хугацаа тодорхой бус байна.

ЖАНССЕН КОВИД-19 ВАКЦИН ЯМАР ЭРСДЭЛТЭЙ ВЭ?

КОВИД-19 вакцины сөрөг нөлөөг дараах байдлаар мэдээлсэн. Үүнд:

- Тарилга хийсэн хэсгийн урвал: өвдөх, арьсны улайх ба хавдах.
- Ерөнхий сөрөг нөлөө: толгой өвдөх, маш их ядрах, булчин өвдөх, дотор муухайрах, халуурах.
- Тунгалагийн зангилаа хавдах.
- Цус бүлэгнэх.
- Арьсны хэвийн бус мэдрэмж (хорсох, гүрвэлзэх мэдрэмж төрөх) (парестези), мэдрэмж багасах эсвэл хэт мэдрэг болох, ялангуяа арьсанд (гипоестези).
- Байнга чих шуугих (чих дүнгэнэх).
- Суулгах, бөөлжих.

Хүнд хэлбэрийн харшлын урвал

Жанссен КОВИД-19 вакцин нь хүнд хэлбэрийн харшлын урвал үүсгэх магадлал багатай. Жанссен КОВИД-19 вакцины эхний тунг хийлгэснээс хойш хэдэн минутаас нэг цагийн дотор маш хүчтэй харшлын урвал үзүүлсэн. Энэ шалтгааны улмаас танд вакцин хийсэн байгууллага таныг вакцин хийлгэсний дараа хяналт тавихын тулд тухайн газартаа хэсэг хугацаанд байх хүсэлт тавина. Хүнд хэлбэрийн харшлын урвалын шинж тэмдгүүд:

- Амьсгалахад хүндрэлтэй болох,
- Нүүр, хоолой хавагнах,
- Зүрх хурдан цохилох,
- Биеийн бүх хэсэгт тууралт гарах,
- Толгой эргэх, сульдах.

Тромбоцитийн доод хэмжээнд хүрч, цусны бүлэгнэл үүсэх

Жанссен КОВИД-19 вакцин хийлгэсэн зарим хүмүүст тархи, уушги, хэвлий, хөлийн судсыг хамарсан цусны бүлэгнэл, тромбоцитийн хэмжээ багасах (таны биеийн цус алдахаас сэргийлдэг цусны эсүүд) тохиолдол гарсан. Цусны өтгөрөлт, тромбоцитийн хэмжээ нь багассан хүмүүст вакцин хийлгэснээс хойш нэгээс хоёр долоо хоногийн дараа шинж тэмдэг илэрч эхэлсэн. Жанссен КОВИД-19 вакцин хийлгэсний дараа 18 ба түүнээс дээш насны хүмүүсийн өргөн хүрээг хамарсан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тромбоцитийн хэмжээ доод түвшинд хүрч, цусны бүлэгнэл үүссэн; 30-аас 49 насны эмэгтэйчүүдэд (1,000,000 тун вакцин тутамд 8 тохиолдол) хамгийн их мэдээлэгдсэн бөгөөд 7 тохиолдол тутмын 1 нь нас барсан байна. Жанссен КОВИД-19 вакцин хийлгэсний дараа танд дараах шинж тэмдэг илэрвэл та даруй эмнэлгийн тусламж авах хэрэгтэй:

- Амьсгал давчдах,
- Цээжээр өвдөх,
- Хөл хавагнах,
- Хэвлий хэсгээр байнга өвдөх,
- Толгой хүчтэй эсвэл байнга өвдөх, нүд бүрэлзэх,
- Тарилга хийлгэсэн хэсгийн арьс хөхөрсөн эсвэл жижиг цусны толбонууд үүссэн.

Дархлааны тромбоцитопени (ИТР)

Дархлааны тромбоцитопени (ИТР) нь тромбоцитийн хэмжээ маш бага түвшинд хүрснээс шалтгаалан амархан эсвэл хэт их хөхрөх, цус алдах шалтгаан болдог эмгэг юм. Жанссен КОВИД-19 вакцин хийлгэсэн зарим хүмүүст ИТР эмгэг тохиолдсон. Энэ хүмүүсийн ихэнхэд нь Жанссен КОВИД-19 вакцин хийлгэснээс хойш 42 хоногийн дотор шинж тэмдэг илэрч эхэлсэн. Ийм тохиолдол үүсэх магадлал маш бага. Хэрэв та ИТР эмгэгээр өвдөж байсан бол Жанссен КОВИД-19 вакцин хийлгэхээсээ өмнө вакцин хийж буй эмчтэйгээ ярилцаарай. Жанссен КОВИД-19 вакцин хийлгэсний дараа танд дараах шинж тэмдэг илэрвэл та даруй эмнэлгийн тусламж авах хэрэгтэй:

- Тарилга хийлгэсэн хэсгийн арьс амархан эсвэл хэт их хөхөрсөн эсвэл жижиг цусны толбонууд үүссэн,
- Хэвийн бус эсвэл хэт их цус алдалт.

Гийен-Барре хамшинж

Жанссен КОВИД-19 вакцин хийлгэсэн зарим хүмүүст Гийен-Барре хамшинж (биеийн дархлааны систем нь мэдрэлийн эсийг гэмтээж, булчин суллаж, заримдаа саажилт үүсгэдэг мэдрэлийн эмгэг) илэрсэн. Энэ хүмүүсийн ихэнхэд нь Жанссен КОВИД-19 вакцин хийлгэснээс хойш 42 хоногийн дотор шинж тэмдэг илэрч эхэлсэн. Ийм тохиолдол үүсэх магадлал маш бага. Жанссен КОВИД-19 вакцин хийлгэсний дараа танд дараах шинж тэмдэг илэрвэл та даруй эмнэлгийн тусламж авах хэрэгтэй:

- Бие сульдах, ялангуяа хөл, гар чимчгэнэх, улам ихсэж, биеийн бусад хэсэгт адил мэдрэгдэх.
- Алхахад хүндрэлтэй болох.
- Ярих, зажлах, залгих зэрэг нүүрний хөдөлгөөн хийхэд хүндрэлтэй болох.
- Давхарлаж харах эсвэл нүдээ хөдөлгөх чадваргүй болох.
- Давсгаа хянахад хэцүү болох эсвэл гэдэсний үйл ажиллагаа хямрах.

Эдгээр нь Жанссен КОВИД-19 вакцины бүх байж болох сөрөг нөлөө биш байж магадгүй. Ноцтой, гэнэтийн сөрөг нөлөө үүсэж болзошгүй. Жанссен КОВИД-19 вакцин нь клиник тандалтын шатанд судлагдаж байна.

СӨРӨГ НӨЛӨӨ ҮҮССЭН ТОХИОЛДОЛД БИ ЮУ ХИЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Хэрэв танд хүнд хэлбэрийн харшлын урвал илэрвэл 9-1-1 утас руу залгах эсвэл хамгийн ойрын эмнэлэгт хандана уу.

Хэрэв та сөрөг нөлөө мэдэрсэн хэвээр, сөрөг нөлөө арилахгүй хэвээр байгаа бол вакцин хийлгэсэн байгууллага эсвэл эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ холбогдоно уу.

Вакцины сөрөг нөлөөг АНУ-ын ХЭЧХГ/ХӨХУСТ-ийн (CDC) Вакцины сөрөг нөлөөний талаар мэдээлэх систем (VCHMC) -д мэдээлэх. VCHMC-ийн 1-800-822-7967 үнэгүй утасны дугаар эсвэл <https://vaers.hhs.gov/reportevent.html> вебсайтад онлайн горимд мэдээлнэ үү. Анкетын 18-р хэсгийн эхний мөрөнд "Жанссен КОВИД-19 вакцины ЯХЗ" гэж оруулна уу.

Мөн та доорх холбоо барих хаягаар Жанссен Биотек Инк (Janssen Biotech, Inc)-д сөрөг нөлөөний талаар мэдээлэх боломжтой.

имэйл	Факсын дугаар	Утасны дугаарууд
JNJvaccineAE@its.jnj.com	215-293-9955	АНУ дахь үнэгүй утасны дугаар: 1-800-565-4008 АНУ дахь үнэгүй утасны дугаар: (908) 455-9922

Мөн та **v-safe** системд бүртгүүлэх боломжтой. **V-safe** бол КОВИД-19 вакцины дараах болзошгүй сөрөг нөлөөг тодорхойлохын тулд вакцин хийлгэсэн хүмүүсийг хянах зорилгоор текст мессеж, вебсайтын судалгаа ашигладаг, ухаалаг гар утсанд суурилсан сайн дурын шинэ хэрэгсэл юм. **V-safe** систем ХӨХУСТ-ийн КОВИД-19 вакцины аюулгүй байдлыг хянахад туслах асуултууд асуудаг. Мөн **V-safe** системээс КОВИД-19 вакцин хийлгэсний дараа хамрагдагсдын эрүүл мэндэд ихээр нөлөөлсөн гэж мэдээлсэн тохиолдолд ХӨХУСТ-өөс утсаар шууд хяналт тавьдаг. Хэрхэн бүртгүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.cdc.gov/vsafe вебсайтад зочилно уу.

ХЭРЭВ БИ ЖАНССЕН КОВИД-19 ВАКЦИН ХИЙЛГЭХИЙГ ХҮСЭХГҮЙ ТОХИОЛДОЛД ЯАХ ВЭ?

ЕUA-аар та вакцинд хамрах эсэхээ өөрөө шийднэ. Хэрэв та Жанссен КОВИД-19 вакциныг хийлгэхгүй гэж шийдсэн бол энэ нь таны стандарт эмнэлгийн үйлчилгээнд өөрчлөхгүй.

ЖАНССЕН КОВИД-19 ВАКЦИНААС ӨӨР КОВИД-19 ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЭХ СОНГОЛТ БАЙДАГ УУ?

КОМИРНАТИ болон СПАЙКВАКС нь ХЭЧХГ-аас зөвшөөрөгдсөн КОВИД-19 вакцин юм. КОВИД-19-өөс сэргийлэх бусад вакциныг ЯХЗ-ийн дагуу хийлгэх боломжтой. Жанссен КОВИД-19 вакциныг зөвхөн бусад КОВИД-19 вакцин хүртээмжгүй эсвэл эмнэлзүйн хувьд тохиромжгүй, мөн Жанссен КОВИД-19 вакцин хийлгэхгүй бол КОВИД-19 вакцинд хамрагдах боломжгүй хүмүүс хийлгэх боломжтой.

БИ ЖАНССЕН КОВИД-19 ВАКЦИНЫГ БУСАД ВАКЦИНТАЙ ЗЭРЭГ ХИЙЛГЭЖ БОЛОХ УУ?

АНУ-ын ХЭЧХГ-т Жанссен КОВИД-19 вакциныг бусад вакцинтай нэгэн зэрэг хэрэглэх талаарх мэдээлэл хараахан ирээгүй байна. Хэрэв та Жанссен КОВИД-19 вакциныг бусад вакцинтай хамт хийлгэхээр төлөвлөж байгаа бол сонголтынхоо талаар эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ ярилцаарай.

ХЭРЭВ БИ ЖИРЭМСЭН ЭСВЭЛ ХӨХҮҮЛ БОЛ ЯАХ ВЭ?

Хэрэв та жирэмсэн эсвэл хөхүүл бол эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ сонголтынхоо тухай ярилцаарай.

ЖАНССЕН КОВИД-19 ВАКЦИНААС НАДАД КОВИД-19 ХАЛДАХ УУ?


Үгүй. Жанссен Ковид-19 вакцин SARS-CoV-2 агуулдаггүй бөгөөд танд КОВИД-19 халдах боломжгүй.

ВАКЦИНЖУУЛАЛТЫН КАРТАА ХАДГАЛНА УУ

Та Жанссен КОВИД-19 хийлгэхдээ вакцины нэр, вакцин хийлгэсэн огноог баримтжуулсан вакцины карт хүлээж авна.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Хэрэв танд асууж лавлах зүйл гарвал эсвэл Жанссен КОВИД-19 вакцины Мэдээллийн Хуудсанд нэвтэрч хамгийн сүүлийн үеийн мэдээлэл авахыг хүсвэл төхөөрөмжөө ашиглан QR кодыг сканердаж, вебсайт руу зочилж эсвэл доор дурдсан утсаар холбогдоно уу.

QR код	Мэдээллийн хуудасны вэбсайт	Утасны дугаарууд
	www.janssenccovid19vaccine.com	АНУ дахь үнэгүй утасны дугаар: 1-800-565-4008 АНУ дахь утасны дугаар: (908) 455-9922

БИ ХЭРХЭН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ ВЭ?

- Вакцин нийлүүлэгчээс лавлаж асууна уу.
- ХӨХУСТ-д вэбсайтад <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/index.html> холбоосоор нэвтэрнэ үү.
- Холбоосын дагуу FDA-тай холбогдоно уу <https://www.fda.gov/emergency-preparedness-and-response/mcm-legal-regulatory-and-policy-framework/emergency-use-authorization>.

Орон нутгийн эсвэл мужийнхаа эрүүл мэндийн хэлтэстэй холбогдоно уу.

МИНИЙ ВАКЦИНЖУУЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ ХААНА ХАДГАЛАГДАХ ВЭ?

Вакцин нийлүүлэгч таны вакцинжуулалтын мэдээллийг танай муж/орон нутгийн харьяа Дархлаажуулалтын мэдээллийн систем (ДМС) эсвэл бусад тусгай системд оруулна. ДМС-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.cdc.gov/vaccines/programs/iis/about.html> холбоосоор нэвтэрч авна уу.

БИ КОВИД-19 ВАКЦИН ХИЙЛГЭСНЭЭР ЗАХИРГААНЫ ТӨЛБӨР ТӨЛӨХ ҮҮ?

Үгүй. Энэ удаа нийлүүлэгч танаас вакцины тунгийн төлбөр авахгүй бөгөөд та зөвхөн КОВИД-19 вакцин хийлгэсэн тохиолдолд вакцин хийлгэсэн болон бусад хураамжийг танаар төлүүлэхгүй. Гэвч вакцин нийлүүлэгчид вакцинд хамрагдсан хүмүүст вакцины захиргааны төлбөрийг аливаа хөтөлбөр, төлөвлөгөөний (хувийн даатгал, Medicare, Medicaid, даатгалгүй вакцин хийлгэгчдэд зориулсан HRSA COVID-19 Uninsured Program) дагуу зохих нөхөн олгох арга зам эрэлхийлнэ.

БИ ЗАЛИЛИНГИЙН СЭЖИГТЭЙ ТОХИОЛДЛЫГ ХААНА МЭДЭЭЛЭХ ВЭ?

ХӨХУСТ-ийн КОВИД-19 Вакцинжуулалтын Хөтөлбөрийг ямар нэгэн байдлаар зөрчсөн тухай мэдээл авсан хүмүүс АНУ-ын Эрүүл мэнд, хүний нөөцийн үйлчилгээний газрын Ерөнхий хянан шалгах хэлтэст 1-800-NHS-TIPS утас эсвэл TIPS.NHS.GOV вэбсайтад хандаж мэдээлнэ үү.

ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХӨТӨЛБӨР ГЭЖ ЮУ ВЭ?

Хохирлын нөхөн төлбөрийн хөтөлбөр (ХНТХ) нь тодорхой эм, вакцин, түүний дотор энэ вакцинаас болж ноцтой хохирсон хүмүүсийн эмчилгээний зардал, бусад тодорхой зардлуудыг нөхөн төлөхөд туслах холбооны хөтөлбөр юм. Ерөнхийдөө вакцин

хийлгэснээс нэг (1) жилийн дотор ХНТХ-т өргөдөл гаргах ёстой. Энэхүү хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.hrsa.gov/cisr вебсайтад нэвтэрч эсвэл 1-855-266-2427 утсаар холбогдоно уу.

ЯАРАЛТАЙ ХЭРЭГЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ГЭЖ ЮУ ВЭ (ЯХЗ)?

АНУ-ын ХЭЧХГ нь Жанссен КОВИД-19 вакциныг ЯХЗ гэж нэрлэгддэг яаралтай хэрэглэх механизмын дагуу ашиглах боломжтой болгосон. Эрүүл мэнд, хүний үйлчилгээний албаны (ЭМХҮА) Нарийн бичгийн даргын мэдэгдлийн дагуу КОВИД-19 цар тахлын үед эм, биологийн бүтээгдэхүүнийг яаралтай хэрэглэх нөхцөл байдал үүссэн үед ЯХЗ олгохыг дэмжсэн.

Жанссен КОВИД-19 вакцин нь АНУ-ын ХЭЧХГ-аас зөвшөөрөгдсөн эсвэл бүрдүүлэлт хийсэн бүтээгдэхүүнтэй адил төрлийн хяналтад ороогүй болно. АНУ-ын ХЭЧХГ нь өөр ямар нэгэн адил төстэй, батлагдсан, боломжит хувилбар байхгүй гэсэн тодорхой шалгуурыг хангасан тохиолдолд ЯХЗ олгоно. Мөн түүнчлэн АНУ-ын ХЭЧХГ-ын шийдвэр уг бүтээгдэхүүн КОВИД-19 цар тахлын үеэр КОВИД-19-өөс сэргийлэхэд үр дүнтэй, мөн тухайн бүтээгдэхүүний мэдэгдэж байгаа болон боломжит үр дүн нь мэдэгдэж байгаа болон болзошгүй эрсдэлээс илүү их нөлөөтэй гэдгийг шинжлэх ухааны бүх нотолгоонд үндэслэсэн байна. Бүтээгдэхүүнийг КОВИД-19 цар тахлын үед ашиглахын тулд эдгээр бүх шалгуурыг хангасан байх ёстой.

Жанссен КОВИД-19 вакцины ЯХЗ нь бүтээгдэхүүнийг цуцлах эсвэл хүчингүй болгохоос бусад тохиолдолд (үүний дараа бүтээгдэхүүнийг цаашид ашиглахгүй) яаралтай хэрэглэхийг зөвшөөрсөн КОВИД-19-ийн мэдэгдлийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

Үйлдвэрлэсэн:
Janssen Biotech, Inc.
Janssen Biotech, Inc.



© 2021 Janssen Pharmaceutical Companies

Дэлгэрэнгүй мэдээллийг АНУ дахь үнэгүй утас: 1-800-565-4008, АНУ-ын утас: (908) 455-9922 эсвэл www.janssencovid19vaccine.com хаягаар авна уу

Хянасан: 2022/05/05



Энэхүү Мэдээллийн хуудсыг вакцин хийлгэсэн хүмүүсийн эрүүл мэндийн цахим бүртгэл/дархлаажуулалтын мэдээллийн системд оруулсныг баглахын тулд сканердаж үзнэ үү.

ББГДТ: 0886983000363